

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№19/496

ШУС, НУС

2018

**БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙГ СУРВАЛЖЛАХАД ГАРГАЖ БУЙ ЁС  
ЗҮЙН НИЙТЛЭГ АЛДААНУУД**

Л.Ариун\*

\*ХИС-ийн Сэтгүүл зүй, медиа технологийн тэнхимийн багш, доктор (Ph.D)

**Түлхүүр үг:** хүний эрхийн мэдрэмж, сэтгүүлчийн ёс зүй, хохирогч төвтэй мэдээлэл, хохирогчийг буруутгах хандлага.

**С**этгүүл зүй нийгмийн тусгал учир хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нийгмийн үй олон сэдэв, үйл явдлыг сурвалжлан бичдэг. Гэхдээ сэтгүүл зүйн ерөнхий онол ойлголтын хүрээгээр баримжаалж тэрхүү үй олон сэдвийг бүгдийг нь үндсэн зарчмаараа бичиж, сурвалжилж боломгүй аж. Ил тод байх ёстой тул нууцын хуулиар хязгаарласнаас бусдыг нээлттэй мэдээлэх, болсон үйл явдлыг үзэгчид өөрөө очсон мэт нүдэнд харагдтал дүрслэн сурвалжлах нь зөв, тухайн асуудалтай хамаатай бүхий л эх сурвалжийн байр суурийг сонс, сурвалжил гэх зэрэг зөвлөмж дүрэм их бий.

Харин хүчирхийллийн хэргийн тухайд дээрх арга барилаас өөр байдлаар сурвалжлах, тэр байтугай бусад төрлийн гэмт хэргээс ч эрс өөрөөр мэдээлэх ёстойг судлаачид хэлэлцэж байна. Манай сэтгүүлчид ч анх удаа “Хүйсийн тэгш эрхийн төв”, “Хэвлэлийн хүрээлэн” хамтарч 2018 оны эхээр зохион байгуулсан “Хохирогч төвтэй мэдээлэл, өмгөөлөл”

сэдэвт сургалтаар энэ хэргийг хэрхэн мэдээлэх нь зөв болохыг мэдэж авсан. Энэ сургалтын үр дүнд оролцсон сэтгүүлчид дээрх сэдвээр сурвалжлага, ярилцлага, мэдээ бэлдэж олон нийтэд хүргэсэн нь зөв хандлага, жишиг тогтоох загвар болж байгаа болов уу. Мөн “Монголын Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн төв”-ийн сургагч багш нарын бэлтгэн гаргасан “Хохирогч төвтэй мэдээлэл: Ажлын байран дахь бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргийг эрэн сурвалжлах нь” сэтгүүлч, редакторуудад зориулсан гарын авлага нь сэтгүүлчдэд дээрх сэдвийг мэдээлэхэд мөн багш, судлаач бидэнд оюутнуудаа зааж ойлгуулах, судалгаа шинжилгээ хийхэд чиг зам болох тун ч өгөөжтэй сурах бичиг болсныг дурдахад таатай байна. Өөрөөр хэлбэл манай сэтгүүлчид, судлаачид, багш нар бэлгийн хүчирхийллийг хэрхэн сурвалжилж, мэдээлэх тухай ойлголт, мэдлэгийг дээр дурьдсан сургалт хийгээд гарын авлагаас авсан. Тиймээс ойлголт, мэдлэгтэй болсон судлаачийн хувьд манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүд бэлгийн хүчирхийллийн сэдвийг хэрхэн яаж тусгаж, сэтгүүлчид хэрхэн яаж сурвалжилдгийг тандах зорилгоор сайтуудын мэдээг судлав.

Мөн “Хохирогч төвтэй Мэдээлэл-Өмгөөлөл” сургалтад суусан сэтгүүлчдийн энэ чиглэлээр мэргэшиж, асуудлаа маш сайн мэдэрч, “Хохирогч төвтэй” хандлагаар нийтлэл нэвтрүүлгийнхээ өнцөг, агуулгыг гаргасан зарим бүтээлүүдтэй танилцлаа.

**М**онголын 20 гаруй мэдээллийн сайтад бэлгийн хүчирхийллийн тухай гарсан 80 орчим мэдээ, нийтлэлд ажиглалт хийв. Сэтгүүлчид дараах нийтлэг алдааг гаргаж, өөрөө ч мэдэлгүй хохирогчийг буруутгах хандлага руу хөтлөж байгааг анхаарахгүй өнгөрч боломгүй санагдлаа.

- Бэлгийн хүчирхийллийн тухай олны анхаарал татах, дуулиан болгох зорилгоор нийтэлж байна  
-“Шуурхай мэдээ: Урьд шөнө дахин 4 настай охин хүчиндсэн хэрэг гарлаа” /topmedee.com/  
-“Криштиану Роналдуг хүчингийн хэрэгт буруутгалаа” /Eagle.mn/  
-“Реппер Нелу хүчингийн хэрэгт холбогдов” /Eagle.mn/  
-“Есөн сарын байдлаар 79 хүүхэд хүчингийн хэргийн хохирогч болжээ” /Eagle.mn/  
-“Охидыг хүчирхийлж амь насанд нь хүрсэн цуврал гэмт хэрэг” /grandnews.mn/ гарчигтай, олны анхаарал татаж сенсаац дэгдээх зорилготой мэдээнүүд олон байна. Энэ эмзэг сэдвийг хөндөхдөө сэтгүүлч хүн ёс зүйг өндөр түвшинд сахиж, хохирогчийг буруутгах хандлагаас зайлсхийх шаардлагатай юм. Хүчирхийллийн тохиолдлыг зөвхөн гэмт хэрэг, хүний эрхийн ноцтой зөрчил гэж гаргах хэрэгтэй<sup>1</sup>.

- Гарчгаасаа эхлээд хохирогчийг буруутгасан үг хэллэг ашиглажээ  
-“Таксины жолооч согтуу эмэгтэйг хүчирхийлсэн хэрэг гарчээ” /Montsame.mn/

-“Архинаас болж охиноо хүчиндсэн хэрэг гарчээ” /bestnews100.com/

-“Биеэ үнэлдэг охид, эмэгтэйчүүдийг хүчиндсэн этгээүүдийг баривчилжээ” /Dnn.mn/

-“Бүсгүйг хүчиндсэн долоон залуугийн нэг нь найз залуу нь байсан гэв” /24tsag.mn/

-“Саваагүйтсэнээс хүчингийн хэргийн хохирогч болж байна” /Eagle.mn/

Дээрх гарчгуудаас “Согтуу байсан тул өөрөө хохирогч болсон байна”, “Архи уугаагүй бол ийм хэрэг хийхгүй байсан”, “Биеэ үнэлдэг тул хүчиндүүлжээ”, “Нэг нь найз залуу нь л байсан юм байна шүү дээ. Ийм хүнтэй яах гэх нөхөрлөдөг байна” гэх мэт ямар нэгэн байдлаар хохирогчийг буруутгах өнгө аяс агуулагдсанаар түүнийг давхар хохироох мэдээлэл болжээ.

Хүчирхийлэлд өртсөн хүний амьдралын хэв маяг, хувцаслалт, биеэ авч яваа байдал, үйлдэл зэргээр нь буруутгах хандлага нийгэмд түгээмэл байна. Хүмүүс өөрсдийнхөө аюулгүй байдлыг мэдрэхийн тулд хохирогчийг буруутгадаг аж. Тухайлбал “Яах гэж өөрөө залуустай хамт архи уудаг байна аа” гэдгийн цаана “Би биеэ зөв авч яваа тул санаа зовох юмгүй” гэсэн далд санаа өрнөдөг байна. Тиймээс л хохирогчийг буруутгах хандлага нийгэмд түгээмэл байдаг<sup>2</sup>. Зөвхөн гарчигт гэлтгүй мэдээний төгсгөлд сэрэмжлүүлэх, анхааруулах үүднээс охид эмэгтэйчүүдийг орой үдэш явахгүй байх, ил задгай хувцаслахгүй байх, хүүхдэдээ хараа хяналт тавих хэрэгтэй зэргээр бичих нь сэтгүүлч өөрийн мэдэлгүй дээрх мэдээнийхээ хохирогчийг буруутгасан өнгө аяс илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл задгай хувцаслаж, орой үдэш явж, залуустай архи ууснаас болж байгаа юм гэх ойлголтыг хүлээн авагчдад өгч байна.

- Сэрэмжлүүлэг өгөхдөө мөн л хохирогчийг буруутгах хандлага руу хөтөлж байна

Ийм гэмт хэрэгт өртөхгүй байх, өөрийгөө болон үр хүүхдээ хамгаалах тухай хэвлэл мэдээлэх сэрэмжлүүлэх нь туйлын зөв. Гэхдээ хүчирхийллээс хэрхэн өөрийгөө хамгаалах, хэрэв өртвөл хүчирхийллийн эсрэг ямар байгуулага мэргэжилтнүүд байгааг мэдээлсэн байдал тун ховор байдаг.

Хүчирхийллийн шалтгаан нөхцөл, анхаарал, сэрэмжийн тухай ямар нэгэн гэмт хэргийн үйл явдлын мэдээллийн төгсгөлд хүргэдэг туйлын буруу, маш том алдаа болдгийг санах хэрэгтэй.

“SOS: Дахин нэг бага насны охин хойд эцэгтээ хүчиндүүлсэн хэрэг гарлаа” /zaluu.com/ мэдээний төгсгөлд “Тиймээс эцэг эхчүүд ээ, төрсөн охиноо хүчирхийлдэг болсон энэ цөвүүн цагт бага насны охиддоо тавих хараа хяналтаа сайжруулж, харгалзах хүнгүйгээр гэрт нь орхихгүй, орой үдэш ганцааранг нь явуулахгүй байх нь гэмт хэрэг үйлдэхээр санаархаж байгаа нэгний үйлдлийг нэн даруй зогсоох хамгийн зөв арга юм шүү гэж хэлмээр байна” гэжээ. Мөн МОНЦАМЭ-гийн “Таксины жолооч согтуу эмэгтэйг хүчирхийлсэн хэрэг гарчээ” мэдээний төгсгөлд “...Сүүлийн үед хүчингийн хэрэг нэмэгдэж гэмт этгээдүүд архи согтууруулах унаа хэрэглэж, биеэ авч явах чадваргүй болсон охид бүсгүйчүүдийг хүчирхийлэх тохиолд-

лууд гарсаар байна. Тиймээс шөнө оройн цагаар эмэгтэйчүүд таксид ганцаараа суухдаа болгоомжтой байж, архи согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, хэрэглэсэн үедээ анхаарал болгоомжтой байхыг албаныхан анхааруулж байна” хэмээн төгсгөснөөр дээрх гэмт хэргүүдийн хохирогчийг шууд буруутгах хандлага гаргажээ. Сэрэмжлүүлэг байх нь зөв үү

гэвэл зөв. Гэхдээ хэн нэгний бодит түүх, үйл явдлаас тусдаа ерөнхий статистик мэдээлэлтэй давхар хүргэвэл хохирогчийг буруутгах хандлага төрүүлэхгүй бөгөөд сэрэмжлүүлэх зорилгоо илүү биелүүлдэг гэж мэргэжилтнүүд зөвлөсөн. Ийм жишээ цөөн ч

«

***Хүчирхийллийн гэмт хэрэгт өртөхгүй байх, өөрийгөө болон үр хүүхдээ хамгаалах тухай хэвлэл мэдээллийн хэрэгсэл сэрэмжлүүлэх нь туйлын зөв. Гэхдээ хүчирхийллээс хэрхэн өөрийгөө хамгаалах, хэрэв өртвөл хүчирхийллийн эсрэг ямар байгуулага мэргэжилтнүүд байгааг мэдээлсэн байдал тун ховор байдаг***

»

гэсэн байсан нь олзуурхууштай. “Хүчингийн хэргийн хохирогч болж буй хүүхдийн тоо нэмэгджээ” /montsame.mn/ мэдээнд “Хөвсгөл аймгийн хэмжээнд хүчингийн гэмт хэргийн хохирогч болсон хүүхдийн тоо нэмэгджээ” гээд 2016 онд ийм тоон үзүүлэлттэй байсан бол 2017 онд ийм болж өссөн тухай дэлгэрэнгүй тоо баримт өгүүлээд “Энэ нь гэр бүл салалт, архидалт, бага насны хүүхдээ хараа хяналтгүй орхих, танихгүй хүнээр харуулах, хойд эцэгтэй болох зэрэг нь үндсэн шалтгаан болж байна. Тиймээс энэ гэмт хэрэгт хүүхдээ өртөхгүй байх талаас нь онцгой анхаарахыг өмгөөлөгч Д.Доржханд хэлж байв” гэжээ.

“Хүчирхийллийн хохирогчид бүх зовлон шаналлыг өөртөө тохох нь элбэг. Энэ нь нийгэмд байдаг хохирогчийг буруутгах хандлагаас үүдэлтэй тул тэднийг ойлгох, сонсох, дэмжих, хаана хандаж, ямар арга хэмжээ авч болох тухай гарц гаргалгааг хэлж өгөх хэрэгтэй” гэж Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн мэргэжилтэн Г.Түвшинжаргал хэлсэн байдаг. Мэргэжилтний энэ үгийг сэтгүүлчид сурвалжлага хийх үедээ байнга санаж байх нь зүйтэй.

- Мэдээллийн өнцөг зөвхөн хохирогчийн тухай мэдээлдэг ба гэмт этгээдийг маш бага дурддаг Японы сэтгүүлч Огава Тамакагийн тэмдэглэснээр хохирогчийн дүрх төрх, нөхцөл байдал, ар гэр, ах дүүс найз нөхөд, хаана амьдардаг тухай мэдээнд дурьдах нь цаагуураа хохирогчийг буруутгах хандлага руу хөтөлдөг хэмээжээ. Үнэхээр бэлгийн хүчирхийллийн сэдэвтэй мэдээнүүдэд хохирогчийн талаар маш дэлгэрэнгүй мэдээлж байна. Тэр ч байтугай ямар нэгэн байдлаар буруутган мэдээлэх нь элбэг.

Жишээлбэл “...хэрэг Сонгинохайрхан дүүргийн 19 хорооны нутаг дэвсгэр Дэлгэх 21 СӨХ-ны харъяанд байдаг орон сууцны подвальд болжээ... Хохиогч Х-ийн аав, ээж хоёр гэр бүлээ цуцлуулсан тул тусдаа амьдарч байжээ” /[todmedee.mn/](http://todmedee.mn/), “Сүхбаатар аймгийн BS телевизэд сэтгүүлчээр ажилладаг эмэгтэйд зургаан залуу харгис хэрцийгээр хүчирхийлжээ... эх сурвалжийн мэдээлж байгаагаар сэтгүүлч бүсгүйн согтууруулах ундаанд ухаан алдуулах зүйл хийсэн байх магадлалтай” /[setguulch.mn/](http://setguulch.mn/). Хүчингийн хэргийн хохирогчийг согтууруулах ундаа хэрэглэсэн тухай алба мэт оруулдаг нь хохирогчийг буруутгах хандлага руу шууд чиглүүлж байна. Мөн түүнчлэн “Опозит

хамтлагийн Энэрэл хүчингийн хэргээр шалгагдаж байна” /[Dorgio.mn/](http://Dorgio.mn/) мэдээнд “...хохиогч ЕБС-ийн охин бөгөөд хувийн байдлын хувьд гэр орноосоо үе үе тэнэн явдаг нэгэн аж. Тухайлбал сурагч охин 2016 оны 03 сард оршин суух хаягаасаа алга болсон гэж эрэн сурвалжлагдаж байгаад хоёр хоногийн дараа олдож байсан юм байна” хэмээн илт хохирогчийг буруутгажээ. Насанд хүрээгүй охиныг хүчирхийлсэн ноцтой хэрэг цагдаагийн байгууллагад шалгагдаж байхад ийн хариуцлагагүй мэдээлж байгаа нь өсвөр насны охиныг цаашид амьдрах итгэл, нийгэмд эзлэх байр суурь, найз нөхөдтэй болох бүхий нөхцөл боломжийг хаах аюултай, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчийн хувьд ёс зүйгээ дээд зэргээр зөрчсөн үйлдэл юм.

Үйл явдлыг хэт дэлгэрэнгүй тайлбарлаж буй нь гэмт этгээд санаа сэдэл авахуйц байна

“Гэрэл асаахын завдалгүй толгой дээгүүр нь бүтээж хүчирхийлсэн” /[grandnews.mn/](http://grandnews.mn/) мэдээнд гарчгаасаа эхлэн үйл явцыг дэлгэрэнгүй дүрсэлжээ. Хэргийн үйл явцыг хэт дэлгэрэнгүй бичих нь гэмт хэргийн сэдэл төрүүлэх, хохирогчийн аюулгүй байдалд эрсдэл учруулах аюултай. Сэтгүүлч заримдаа болсон үйл явдлыг уншигчдынхаа нүдэнд харагдтал дүрслэхийн тулд гэмт хэрэг болох үед хохирогч юу өмсөж байсан, юу хийж байсан зэргийг хүртэл дурддаг байна. Гэтэл ингэснээр нийгэмд түгээмэл байдаг хохирогчийг буруутгах хандлагыг өдөөх тохиолдол бий<sup>3</sup>. “...Хоолойг нь боож, хонгил руу чирээд ...” гэх мэтээр дүрслэх нь гэмт этгээдэд санаа сэдэл өгөх магадлалтай. Киноноос болон хэвлэлээс үзсэн харснаа дуурайн хийсэн гэмт хэргийн жишээ олон байдгийг мартаж болохгүй.

- Гэмт этгээд ямар ял шийтгэл авж байгаа талаар огт мэдээлдэггүй

Зүй нь ийм гэмт хэрэг хийсэн хүн ямар ял шийтгэл хүлээж байгааг мэдээлж энэ хэргийг хохирогч болсон хүмүүс ийнхүү олон нийтэд дэлгэж байгаа эр зоригийг магтаж, хүчирхийллээс хамгаалах байгууллагуудыг зааж өгч хэнд хэрхэн хандаж эрхээ хамгаалуулах, зөвлөгөө авах, эмчлүүлэх тухай дэлгэрэнгүй хэлж өгвөл цаашид ийм гэмт хэрэг гарах нөхцлийг бууруулах, ил гарч ирж чадахгүй байгаа олон мянган хохирогчид зориг итгэл өгөх, мөн хохирогч хэнд хандах вэ зэргээ мэддэг болох гээд жинхэнэ утгаараа хэвлэл мэдээлэл үүргээ биелүүлж иргэд олон нийтийн эрх ашгийг хамгаалах юм. Хүчирхийлэлд өртөгсдийн эрхийг хамгаалах, сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө өгч цаашид нийгэмд хөлөө олох, амьдрах итгэлээ олж авахад тусладаг төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагууд, мэргэжилтнүүд цөөнгүй бий. Ийм мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллах, хэрхэн мэдээлэх, сэргийлэх, туслах ёстойгоо мэдэх нь манай сэтгүүлчдийн үүрэг болоод байна.

**Г**анцхан манайд л сэтгүүлчид бэлгийн хүчирхийллийн хэргийг сурвалжлахдаа алддаг юм биш. Сэтгүүл зүй өндөр хөгжсөн, тэр тусмаа хувь хүний ёс суртахууны маш өндөр хөгжилтэй Японд улсад хэвлэл мэдээлэл нь хүчингийн хэргийн тухай мэдээлэхдээ алдаа гаргаснаар судлаачид энэ тухай маргаан, хэлэлцүүлэг өрнүүлэхэд хүргэжээ.

Одоогоос хоёр жилийн өмнө Японы алдарт жүжигчин, 23 настай залуу орон нутагт томилолтоор ажиллахдаа буудлын угтагч 40 гаруй настай

эмэгтэйг хүчиндсэн хэрэг гарсан. Шүүх үнэн худлыг шалгаж тогтоогоод гэмт хэрэг хийсэн жүжигчин залуу шүүхээс ял аван, телевизээр болон олон нийтийн өмнө гарах эрхээ тодорхой хугацаагаар хасуулан шийтгүүлсэн аж. Харин энэхүү хэрэг явдлын тухай Японы хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ёс зүйгүй, мэдрэмжгүй мэдээлсэн байна. Гэмт хэрэгтнийг өмөөрч, хохирогчийг буруутгах өнгө аястай мэдээ олон цацагджээ. Тухайлбал гэмт хэрэг хийсэн жүжигчинг залуухан, царайлаг, харин хохирогчийг хөгшин, хөдөөний гэх агуулга мэдээнүүдэд багагүй байсан аж. Томоохон нэр хүндтэй телевизүүд хүртэл хохирогч эмэгтэйн насыг байн байн мэдээлж, түүгээр ч барахгүй гадна төрхийг нь дүрсэлж “.. тэр жүжигчинтэй төстэй царайтай” хэмээн тодотгон мэдээлжээ. Шар хэвлэлүүд нь гэмт хэрэгтнийг илт өмөөрч “эмэгтэй өөрөө өдсөн байх” гэж хүртэл бичжээ. Дээрх үйл явдлын дуулиан шуугианы дараа хүчингийн хэргийг хэрхэн мэдээлэх нь зөв тухай Японы сэтгүүлч, судлаач Огава Тамакагийн бичсэнийг үзлээ. Тэрээр Хүчингийн хэргийн хохирогч хэн байдаг вэ? тухай дараах таван хэвшмэл ойлголт олон нийтийн болон сэтгүүлчдийн дунд байдаг гэжээ.

- *Залуухан эмэгтэй*
- *Царайлаг эмэгтэй*
- *Задгай хувцасласан эмэгтэй*
- *Өдөх маягийн үйлдэл хийсэн эмэгтэй*
- *Зөвхөн эмэгтэйчүүд<sup>4</sup>*

Дээрх буруу ойлголт хандлага ямар муу үр дагавартай вэ хэмээвээс хамгийн эхлээд энэ ойлголтоос болж цагдаад хандаж чадахгүй болдог. “Би залуухан биш, царлайлаг биш болохоор цагдаа итгэхгүй байх” гэсэн бодлоос үүдээд хохирогч гэмт хэргийн



тухай мэдээлж өөрийгөө хамгаалуулах арга хэмжээ авдаггүй гэнэ. Цаашлаад хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарвал олон нийт итгэхгүй, буруутгах хандлага гаргана гэхээс эмээдэг байна.

Үнэхээр сэтгүүлчид ийм ойлголт хандлагаар мэдээлвэл хохирогчийг давхар хохироож, тухайн хүний нийгэмд ажиллах орон зай, цаашлаад энэ хорвоо дээр амьдрах итгэл сэтгэлийг үгүй хийх аюултай тухай хүний эрхийг хамгаалах мэргэжилтнүүд болон сэтгүүл зүй судлаачид олон жишээ баримтаар өгүүлсэн байдаг.

Хүчингийн хэргийг хэрхэн мэдээлэх нь зүйтэй вэ гэдэгт Огава Тамака ийн хариулжээ.

- ✓ Хохирогчийг ил гаргахгүйгээр мэдээлэх нь хамгийн эхний дүрэм байх ёстой. /Хаана амьдардаг, хэн гэдэг, ямар ажил хөдөлмөр эрхэлдэг, ямар ажил төрөл хийдэг зэргийг огт мэдээлэхгүй/
- ✓ Өөрөө хохирсон тухай мэдээлж, зарласан эр зоригийг нь магтан, сайшаах. /Бусад хохирогчдод итгэл найдвар, урам зориг өгч, цагдаад мэдээлэх байдал өснө/
- ✓ Өөрийгөө ил зарлана гэдэг бол маш их зориг учраас бусдаас хамгаалах. Ялангуяа өөр хэвлэл мэдээллийн хэрэгсэл сенсаац хөөх, дуулиан шуугиан болгох зорилгоор хохирогчийн тухай мэдээлэх гэж оролдвол мэргэжлийн үүднээс хатуу шүүмжлэх хэрэгтэй гэжээ<sup>5</sup>.

Судлаач, мэргэжилтнүүдийн зөвлөж буйгаар хүчингийн хэрэгт 100 хувь гэмт хэрэгтний буруу байдаг гэдэг өнцөг байр сууринаас асуудалд хандаж мэдээ, нийтлэлээ бичвэл хамгийн зөв. “Охид эмэгтэйчүүд яагаад ийм гэмт хэрэгт өртөөд байна вэ?” гэсэн асуултаар асуудалд хандвал хохирогчийг буруутгах хандлага руу орчихно.

Харин эсрэгээр нь “Яагаад ийм гэмт хэрэг хийгээд байна вэ?” гэж сурвалжилж болох аж. Дээрх хоёр өнцгийг солиход л мэдээллийн агуулга зөв, буруу хоёр тийшээ маш амархан эргэнэ. “Яагаад хүчиндүүлэв” биш, “Яагаад хүчиндэв”. Dorgio.mn сайтаас үзсэн дөрвөн мэдээний гарчгийг авч үзвэл, “Бага насны охин хүчиндүүлсэн хэрэг дахин гарчээ”, “Охиноо хүчиндүүлсэн гэх эмэгтэйн ээж байх эрхийг хасуулахаар шүүхэд санал хүргүүллээ”, “Найман хүүхэд тутмын нэг нь бэлгийн хүчирхийлэлд өртөж байна”. Нөгөө л буруу хандлага, буруу үг сонголт байгааг анхаарах хэрэгтэй.

**С**этгүүлч өөрөө ч мэдэлгүй хохирогчийг буруутгах хандлагатай нийтлэл бичдэг нь дараах алдаанаас болж байдаг.

- Хохирогчийн гадаад байдлыг дүрслэх /Хэзээ ч болохгүй үйлдэл. Энэ нь ихэнхдээ уншигчдад буруу ойлголт өгч хохирогчийн буруутгах хандлага төрүүлдэг/
- Хохирогчийн ар гэр, ах дүү, найз нөхдөөс мэдээлэл авах /Огт болохгүй. Дийлэнхдээ дуулиан, шуугиан болгох зорилгоор хэвлэл мэдээлэл, сэтгүүлчид ингэж сурвалжилдаг/
- Хүчингийн хэргийг бэлгийн харьцаа болон хайр дурлалтай хольж бичдэг. /Хольж болохгүй. Хайр дурлал бол тусдаа асуудал. Мөн үг давтахсаа зайлсхийхдээ бэлгийн харьцаа гэдэг үг сонгодог нь маш том алдаа/<sup>6</sup>.

Дээрх алдаанууд судалгаанд түүвэрлэгдсэн хэд хэд мэдээнд гарсан. 24tsag.mn сайтад нийтэлсэн “Бүсгүйг хүчиндсэн долоон залуугийн нэг нь найз залуу нь байсан гэв” гарчигтай мэдээнд “...харин цагдаагийн байгууллагын эх сурвалжийн мэдээлснээр

бүсгүй анх “Орхон” зочид буудалд найз залуутайгаа өрөө авч, хөтлөлцөн орсон. Харин найз залуу нь найзуудыгаа дуудсан байгаа юм...”, “Орлогч дарга найзтайгаа хардаж бүсгүйг тамласан уу”, “...хардалтаас болж бүсгүйг зодож...” зэргээр бичсэн нь хүний эрхийн ноцтой зөрчил, гэмт хэргийг агуулгыг сулруулж, хохирогчийг буруутгах хандлага төрүүлэхүйц болсон байна<sup>7</sup>.

Өөр төрлийн гэмт хэрэг дээр хохирогчийн ар гэр, сэтгэл санааны байдал, туулж ирсэн амьдрал зэргийг мэдээлж болдог. Энэ нь сэрэмжлүүлэх зорилготой. Тухайлбал мөн л хоёр жилийн өмнө Японд “Үхэх хүсэлтэй хүмүүсийг алж өгнө” гэсэн зарыг интернетэд тавиад зарын дагуу ирсэн есөн хүний мөнгийг авч амь насыг нь бүрэлгэсэн гэмт хэрэг гарсан. Энэ хэргийн хохирогчдын бодит нэр ус, амьдралын тухай Японы хэвлэл мэдээлэл дэлгэрэнгүй мэдээлжээ. Энэ нь гэр бүлийнхнийхээ сэтгэл зүйг ойлгох, туслах, гэр бүлийн гишүүнээ хаана юу хийж явааг анзаарах хэрэгтэй гэсэн сэрэмжлүүлэг санааг олон нийтэд өгөх зорилготойгоороо ялгаатай. Харин хүчингийн хэргийн хувьд хохирогчийн бодит амьдрал нэр усыг мэдээлж огт болохгүй гэсэн зарчмыг сэтгүүлчид барих нь зүйтэй.

Энэ сэдвээр мэргэшиж, ойлголт мэдлэгтэй болсон, хүн ёс, ёс зүйн ойлголтыг сайн мэдэрч чадаж байгаа сэтгүүлчдийн цөөнгүй нийтлэл нэвтрүүлэг Монголын хэвлэл мэдээллээр олон нийтэд хүрсэн. Сэтгүүлч Х.Хулан, Ж.Мандхай, З.Цэлмэг нарын хүний эрх, хүйсийн тэгш байдал, хохирогчийн эрх, хамгааллын асуудлыг тойрсон “Жинхэнэ шарх сэтгэл зүйд үлддэг” цуврал ярилцлага, “Хөвгүүд зүгээр биш байна”,

“Хүүхдээс илүү ялтанг халамжилдаг төр” бүтээлүүд нь олон нийт тэр ч байтугай сэтгүүлчдийн тэр бүр яриад, мэдээд байдаггүй асуудлыг дэвшүүлж зөв ойлголт, хандлага төрүүлэхүйц бичсэн байна. Хамгийн гол нь хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч сэтгэл зүйн ямар байдалд ордог, тэднийг хэрхэн хамгаалж, эргэж хэвийн амьдралд нь оруулах тухай маш олон талаас нь тодорхой гаргажээ. Энэ талаар илүү дэлгэрэнгүй судалгаа хийж хүний эрхийн мэдрэмжтэй, мэргэшсэн сэтгүүлчийн бүтээл ямар байх ёстойг жишээ баримтаар харуулах нь цаашдаа олон сэтгүүлч алдаа гаргахгүй байх, зөв хандлага ойлголтоор бичиж сурахад тус дэм болох учиртай.

Сэтгүүлч хүчирхийллийн гэмт хэргийг сурвалжлахдаа мэдлэгтэй, мэдрэмжтэй, мэргэжлийн ёс зүйтэй мэдээлэхгүй бол хохирогчийг давхар хохироож, нийгэм олон нийтэд буруу ойлголт хандлага төлөвшүүлэн ийм гэмт хэргийг бууруулах, сэрэмжүүлэх үүрэгтэй мэргэжлийн байгууллагын ажилд чөдөр тушаа болох уршигтай юм. Дүгнэж хэлэхэд ийм төрлийн гэмт хэргийг сурвалжлахад өөрийн төрөлх зөн совин, мэдрэмжээрээ бичих боломжгүй тул сэтгүүлчдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, давтан сургах, тусгай арга барилд суралцуулах нь зүйтэй. Тиймээс хүчирхийллийн гэмт хэргийг хэрхэн мэдээлэх, сурвалжлах тухай сургалт, семинар, хэлэлцүүлэг, судалгааг цаашид өргөжүүлэх, хөгжүүлэх шаардлага мэргэжлийн байгууллага, сэтгүүлч, судлаачдын өмнө байна.

#### Ишлэл

- <sup>1</sup> Мөнхчимэг Д. 2018. Хохирогч төвтэй мэдээлэл. УБ. 40 дэх тал
- <sup>2</sup> Мөнхчимэг Д. 2018. Хохирогч төвтэй мэдээлэл. УБ. 39 дэх тал

<sup>3</sup>Мөнхчимэг Д. 2018. Хохирогч төвтэй мэдээлэл. УБ. 34 дэх тал

<sup>4</sup><https://news.yahoo.co.jp/byline/ogawatamak/20160826-00061516>

<sup>5</sup><https://news.yahoo.co.jp/byline/ogawatamak/20160826-00061516>

<sup>6</sup><https://news.yahoo.co.jp/byline/ogawatamak/20160826-00061516>

<sup>7</sup>Мөнхчимэг Д. 2018. Хохирогч төвтэй мэдээлэл. УБ. 35 дах тал

#### **Ашигласан бүтээлийн жагсаалт**

1. Зулькафиль М, Чойсамба Ч. 2014. Сэтгүүлчийн ёс зүй. УБ.
2. Болормаа П. 2015. Хүний эрхэд суурилсан хандлага. УБ.
3. Мөнхчимэг М. 2018. “Хохирогч төвтэй мэдээлэл: Ажлын байран дахь бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргийг эрэн сурвалжлах нь. УБ.

4. Глоб интернэшнл, Бие даасан боловсрол, хөгжлийн төв. 2018. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн гарын авлага. УБ.

#### **Abstract**

As long as journalists who acknowledged on human rights and professional ethics don't report critical cases like sexual abuse and harassment, victims and organizations that in charge of defend the society and its psychology would encounter harm and dysfunction. In order to reporting about sexual harassment or abuse journalist cannot use their hunch. Because researchers founded that the society and journalists have very wrong stereotypes on this theme. Thus journalists needed to be broaden their knowledge and reinforce their skills on this matter.